

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2025 оны 02 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2025.02

ДНБ-ий өсөлт

(2024 он)

4.9 хувь

Гадаад валютын нөөц

(2025 оны 2 дугаар сар)

4,763 сая \$

Инфляц

(2025 оны 2 дугаар сар)

9.6 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 2 дугаар сар)

-566 тэрбум ₮

Экспорт

(2025 оны 2 дугаар сар)

2,005 сая \$

Импорт

(2025 оны 2 дугаар сар)

1,711 сая \$

ГШХО

(2024 он)

4,005 сая \$

Зээлийн хүү

(2025 оны 2 дугаар сар)

17.1 хувь

Ажилчдын тоо

(2024 оны 4 дүгээр улирал)

1.35 сая

*IV улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62.2 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2024 оны 4 дүгээр улирал)

7.9 хувь

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2024 оны эцэс)

108.4 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2024 оны 4 дүгээр улирал)


5.9 хувь



Монгол Улсын эдийн засаг 2024 онд 4.9 хувиар өсөж, нэрлэсэн ДНБ 80 их наяд төгрөгт, нэг хүнд ногдох ДНБ 6,890 ам.долларт хүрлээ. Худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжил болон татварын орлого сайн байсан нь эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Харин хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын уналт өсөлтийг хязгаарлав.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(2024 он)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

■ Бодит ДНБ 2024 онд **4.9 хувиар өслөө.**

- Анхдагч салбар: Уул уурхайн салбар 10.8 хувиар тэлж, өсөлтийн 1.4 хувийг бүрдүүлсэн бол ХАА-н салбар 28.7 хувиар агшиж, нийт өсөлтийг -3.6 нэгж хувиар хязгаарлалаа.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 2.5 хувиар өсөж өсөлтийн 0.3 нэгж хувийг;
- Үйлчилгээний салбар /худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 9.8 хувиар өсөж өсөлтийн 4.8 хувийг;
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 16.1 хувиар өсөж өсөлтийн 2.0 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.

- 2024 онд худалдааны үйлчилгээний салбарын идэвх сайн байж, татварын орлого нэмэгдэн, эдийн засгийн өсөлтийг голлон дэмжив.
- Харин том малын зүй бус хорогдол оны эхнээс нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар уналттай байв.


- Уул уурхайн салбар 2024 онд 10.8 хувиар өсөв.
- Нүүрс олборлолт 100.1 сая тоннд хүрч, өмнөх оноос 23 хувиар өссөн нь гол нөлөөллөө.
- Мөн зэсийн баяжмалын үйлдвэрлэл 12 хувиар, төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмалын олборлолт 32 хувиар нэмэгдсэн байна.
- Харин алт болон газрын тосны олборлолт тус тус 15 болон 14 хувиар буурч, тус салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлөв.

- ХАА-н салбар 2024 онд улиралд 28.7 хувиар агшлаа.
- Том малын зүй бус хорогдол 9.4 сая толгойд хүрч өмнөх оноос 4.4 сая толгой малаар нэмэгдсэн байна. Энэ нь 2024 оны эхэнд тоологдсон нийт малын 14.5 хувьд хүрч, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл жил дараалан буурлаа.
- Нийт малын тоо 57.6 сая толгой болж, 2015 онтой ойролцоо түвшинд хүрлээ.
- Нийт тариалсан талбай өнгөрсөн оноос 1.5 хувиар, хураасан улаан буудай 5.4 хувиар тус тус буурлаа.




PMI индекс тэлэлтийн төлөвт хадгалагдаж 58.5 хувь гарсан ч өмнөх улирлаас 2.5 нэгж хувиар буурлаа.

PMI (50=өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, гол салбараар (50=өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, аж ахуй нэгжийн төрлөөр (50=өөрчлөлтгүй)



Эх сурвалж: Монголбанк

PMI, үзүүлэлтүүдээр (50=өөрчлөлтгүй)



Эх сурвалж: Монголбанк

- Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг хэмждэг Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2024 оны 4 дүгээр улиралд 58.5 хувь болж, өмнөх улирлаас 2.5 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 0.1 нэгж хувиар тус тус суларсан байна.

- Барилгаас бусад салбарын бизнесүүд эерэг хүлээлттэй байна.
- Уул уурхайн өсөлтийн нөлөөгөөр аж үйлдвэрийн салбарын PMI хамгийн өндөр буюу 63.4 хувь байна.
- Харин үйлчилгээний салбаруудын PMI өмнөх улирлаас 8.6 нэгж хувиар буурч, 54.7 хувь болсон байна.
- Худалдааны салбарын PMI 2.8 нэгж хувиар сайжирч, 53.6 хувь болжээ.

- 200-гаас дээш ажиллагсадтай том аж ахуй нэгжүүдийн PMI индекс 63.2 хувь болж, өмнөх улирлаас 1.8 нэгж хувиар муудав.
- Харин 50-199 ажиллагсадтай дунд хэмжээтэй аж ахуй нэгжүүдийн хувьд өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар дээшилж 50.1 хувь болж, эерэг төлөвт шилжжээ.
- Харин жижиг бизнесүүд сөрөг хүлээлттэй хэвээр байна.

- Бизнесүүд шинэ захиалгын тоо, үйлдвэрлэлийн хэмжээ, бараа материалын нөөц, ажил эрхлэлт нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа бол нийлүүлэлтийн хүргэлтийн хугацаа сүүлийн 16 улирлын турш уртассан гэж харилуулсан байна.



Эцсийн ашиглалтын аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 онд 5.0 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжсэн бол хэрэглээ, хөрөнгө оруулалтын идэвхжилийг даган бараа, үйлчилгээний импорт нэмэгдсэн нь нийт өсөлтийг сааруулав.

ДНБ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ


(жилийн өсөлтийн хувь)



- Эдийн засгийн өсөлтөд дотоод эрэлт голлон нөлөөлөв. Нийт өсөлтийн 8.6 нэгж хувийг өрхүүдийн хэрэглээ, 3.6 нэгж хувийг засгийн газрын хэрэглээ, 6.2 нэгж хувийг хөрөнгө оруулалт бүрдүүлсэн байна.
- Харин импортын эрчимтэй өсөлт цэвэр экспортыг бууруулж, өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ


(жилийн өсөлтийн хувь)



- Төрийн хэрэглээний өсөлт 2024 оны сүүлийн хагаст саарч, жилийн дүнгээр 18.3 хувьд хүрэв.
- Цалин, тэтгэвэр, тэтгэмж өссөний зэрэгцээ хэрэглээний зээл олголт нэмэгдсэн нь 2024 онд өрхийн хэрэглээг дэмжиж, өрхийн хэрэглээ урьдчилсан гүйцэтгэлээр 12.9 хувиар өссөн байна.

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН БҮТЭЦ

(жилийн өсөлтийн хувь)



- Үндсэн хөрөнгийн хуримтлал 19.7 хувиар өсөхөд уул уурхайн хүнд машин механизм болон авто зам зэрэг инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалт өссөн нь голлон нөлөөллөө.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)




- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 0.7 хувиар өссөн бол хэрэглээ, хөрөнгө оруулалт идэвхэжсэнээр бараа, үйлчилгээний импорт 17.7 хувиар өслөө.



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 2 сард 16.4 хувиар өсөв. Зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт нэмэгдсэн бол нүүрс, алт, газрын тос олборлолтын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс багасав. Мөн нүүрсний үнийн нөлөөгөөр уул уурхайн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс буурав.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ


(гэрбум төгрөг)



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний 2 сард 5.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.8 хувиар өслөө.
- Зэсийн баяжмал болон төмрийн хүдрийн олборлолт нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 19.2 хувиар нэмэгдлээ.
- Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл (нэрлэсэн дүнгээр) 2025 оны эхний 2 сард 12.6 хувиар өсөхөд сүүн бүтээгдэхүүн болон хүнсний бусад бүтээгдэхүүн, химийн бодисын үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.

НҮҮРС ОЛБОРЛОЛТ

(сая тонн)



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг уул уурхайн салбар, түүн дотор 43 хувийг нь нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2025 оны эхний 2 сард 13.4 сая тоннд хүрч, өмнөх оноос 4 хувиар буурав.


УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ

(голлох бүтээгдэхүүнээр)



- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2025 оны эхний 2 сард нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 20 хувиар өслөө.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 727 мянган тоннд хүрч, 3 хувиар өсөөд байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс доогуур байна.

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)




- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2025 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурсан байна.
- Үнэ өссөн:
- Хүнсний бүтээгдэхүүн 7.8 хувиар;
 - Ундаа үйлдвэрлэл 10.1 хувиар;
 - Тавилгаас бусад мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 88.2;
 - Цахилгаан, хий, уур, агааржуулалт 80.7 хувиар тус тус өссөн бол
- Үнэ буурсан:
- Нүүрс олборлолт 9.4 хувиар;
 - Газрын тос олборлолт 3.4 хувиар
 - Металлын хүдэр олборлолт 4.7 хувиар тус тус буурсан байна.



Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2025 оны 2 дугаар сард үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүнгээр 7.2 хувиар өслөө. Мах, арьс шир, гурил, бүх төрлийн ундааны үйлдвэрлэлийн биет хэмжээ буурч, сүү, нэхмэл эдлэл, тэсэлгээний бодисын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.

МАХ


(мян. тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГУРИЛ


(мян. тонн)



Эх сурвалж: ЭЭХЯ-ны тооцоолол, ҮСХ

УНДАА


(мян. тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

НООЛУУРАН СҮЛЖМЭЛ ЭДЛЭЛ

(мян. ширхэг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Боловсруулсан малын мах 2025 оны эхний 2 сард 6.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 23 хувиар буурлаа.
- Махны биет хэмжээний бууралтын нөлөөгөөр боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар буураад байна.

- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 2 сард 29.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 9 хувиар буурлаа.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурсан голлох нөлөөгөөр боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 19.1 хувиар буурлаа.

- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 2 сард 88.2 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар буурлаа.


- Ноолууран сүлжмэл эдлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 2 сард 63 мянган ширхэг болж, өмнөх оны мөн үеэс 5 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээний өсөлтийн голлох нөлөөгөөр боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэлийн бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оноос 35.5 хувиар өссөн байна.



Инфляц эрчимжсэний нөлөөгөөр худалдаа, үйлчилгээний салбаруудын бодит орлогын дүн 2025 оны 1 сарын байдлаар бууралттай байна. Нүүрсний олборлолт, экспорт буурснаар төмөр замаар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс саарлаа. Харин улсын хилээр орсон жуулчдын тоо 18 хувиар өссөн байна.

ХУДАЛДАА


(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)



Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг.
Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, ҮСХ

ЗОЧИД БУУДАЛ, ХООЛ

(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)



Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг.
Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, ҮСХ

ТЭЭВЭР


(тээсэн ачаа, сая тонн)

	2024.02	2025.02	ӨМНӨХ ОНООС:
Төмөр зам	7.0	6.9	-1%
Уул уурхайн бүт.	5.1	4.9	-4%
Агаар*	1.4	1.3	-7%
<hr/>			
	2023.12	2024.12	
Авто зам	69.9	85.2	22%
Уул уурхайн бүт.	66.9	81.9	22%

Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик нь улирлаар зарлагддаг.
Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

(жуулчдын тоо, мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар эзэлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2025 оны 1 дүгээр сард нэрлэсэн дүнгээр 5.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 6.8 хувиар өссөн байна. Харин үнийн нөлөөг засварласан бодит орлогын дүн 0.6 хувиар буурав.




- Зочид буудал болон нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 2025 оны 1 дүгээр сард нэрлэсэн дүнгээр 15.7 хувь болон 9.0 хувиар тус тус өссөн байна.
- Харин инфляц эрчимжсэнээр үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлогын дүн 0.6 хувиар, нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 6.4 хувиар буурсан байна.

- Төмөр замаар 2025 оны эхний 2 сард 6.9 сая тонн ачаа тээвэрлэж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хувиар буурсан байна. Үүнд, нүүрс болон нефтийн бүтээгдэхүүний тээвэр буурсан нь гол нөлөөлөв.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 7 хувиар буурсан байна.
- Авто замаар 2024 онд 85.2 сая тонн ачаа тээвэрлэсний 81.9 сая тонн буюу 96 хувь нь уул уурхайн бүтээгдэхүүн байна.

- 2025 оны эхний 2 сард Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 63.3 мянгад хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 хувиар өссөн байна.



2025 оны эхний 2 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 3.7 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 294 сая ам.долларын ашигтай гарлаа.



- Экспорт 2025 оны 2 дугаар сард 2,005 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 11 хувиар буурлаа.
- Нийт экспортын 94 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа нүүрсний экспорт дангаараа 54 хувийг бүрдүүлж байна.

- Нүүрсний экспортын орлого 893 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 34 хувиар буурлаа.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 553 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 24 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 164 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 8 дахин өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 80 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 11 хувиар буурлаа.

- 2025 оны 2 дугаар сарын байдлаар импорт 1,711 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн байна.
- Нийт импортын 18 хувийг тоног төхөөрөмж, 21 хувийг нефть, 14 хувийг суудлын автомашин эзэлж байна.


- Тоног төхөөрөмжийн импорт 305 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13 хувиар өслөө.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 367 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12 хувиар өслөө.
- Суудлын автомашины импорт 232 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 27 хувиар өслөө.
- Барилгын материалын импорт 137 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 22 хувиар өслөө.



2025 оны 2 дугаар сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 94 хувийг, тэр дундаа нүүрс болон зэсийн баяжмал дангаараа 88 хувийг бүрдүүллээ.

НҮҮРС


(сая тонн)



- Нүүрсний экспорт 2025 оны эхний 2 сард 11.4 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өслөө.

ЗЭСИЙН БАЯМЖАЛ


(мян. тонн)



- Зэсийн баяжмалын экспорт 2025 оны эхний 2 сард 281 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 10.8 хувиар өслөө.

ТӨМРИЙН ХҮДЭР


(мян. тонн)



- Төмрийн хүдрийн экспорт 2025 оны эхний 2 сард 608 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар буурлаа.

ГАЗРЫН ТОС

(мян. баррель)




- Газрын тосны экспорт 2025 оны эхний 2 сард 1,092 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар буурлаа.



2025 оны эхний 2 сард голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.

МАЛЫН МАХ


(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

АРЬС ШИР


(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООЛУУР


(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС

(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Малын махны экспорт 2025 оны эхний 2 сард 24 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 36 хувиар буурлаа.
- Тэр дундаа боловсруулсан махны экспорт өмнөх оны мөн үеэс 3 дахин багассан байна.

- Боловсруулсан арьс ширний экспорт 2025 оны эхний 2 сард 71 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 48 хувиар буурлаа.

- Ноолуурын экспорт 2025 оны эхний 2 сард 7 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 52 хувиар буурлаа.

- Ноосны экспорт 2025 оны эхний 2 сард 135 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 84 хувиар буурлаа.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

ЗЭС


(\$/тонн, Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

ТӨМРИЙН БАЯЖМАЛ


(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламттай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Brent)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2025 оны 2 дугаар сарын дундаж үнэ 180 ам.долларт хүрч, өмнөх сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 37 хувиар буурсан байна.

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2025 оны 2 дугаар сарын дундаж 9,616 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 10 хувиар өссөн байна.

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2025 оны 2 дугаар сарын дундаж үнэ 101 ам.долларт хүрч, өмнөх сараас 4 хувиар, өмнөх оны мөн үеэс 7 хувиар буурсан байна.


- Бrent газрын тосны 2025 оны 2 дугаар сарын дундаж үнэ 70 ам.долларт хүрч, өмнөх сараас 5 хувиар буурсан хэдий ч өмнөх оны мөн үеэс 9 хувиар өслөө.



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 2 сард 429 мянган тонн нүүрс, 1.9 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 3.3 мянган тонн жоншны баяжмал, 4.5 мянган тонн зэсийн баяжмал арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА

(сая тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2025 оны 2 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 37.7 сая тонн нүүрс арилжиж, 4.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 2 сард 0.4 сая тонн нүүрс борлууллаа.

НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2025 оны 2 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 104 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 104 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 2 дугаар сард хэлцлийн доод үнэ 72 ам.доллар, дээд үнэ 114 ам.долларт хүрэв.

ТӨМРИЙН АРИЛЖАА

(мянган тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- 2025 оны 2 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 5.0 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 338 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 2 сард 1.9 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ

(ам.доллар/тонн)




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

- Төмрийн хүдэр болон баяжмалын 2 дугаар сарын дуудах дундаж үнэ 62 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 62 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 2 дугаар сард хэлцлийн доод үнэ 55 ам.доллар, дээд үнэ 88 ам.долларт хүрэв.




Санхүүгийн дансны ашиг буурснаар төлбөрийн тэнцэл 2025 оны 1 дүгээр сард 681 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 2 дугаар сарын эцэст өмнөх сараас 121 сая ам.доллоороор буурлаа.


ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ (сая ам.доллар)



ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ (сая ам.доллар)



ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ (төгрөг/ам.доллар)



ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА (сая ам.доллар)



- Төлбөрийн тэнцэл 2025 оны 1 дүгээр сарын эцэст 681 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Тэнцэл өмнөх оны мөн үеэс 594 сая ам.доллоороор буурахад санхүүгийн дансны ашиг буурсан нь голлон нөлөөллөө.
 - Тухайлбал, өмнөх оны 1 дүгээр сард МИК гадаад бонд гаргасан, шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал* 133 сая ам.доллоороор их байв.
 - Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 185 сая ам.доллоороор буурсан бол импорт 1 сая ам.доллоороор нэмэгдлээ.
- *Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон эзлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгалыг хассан дүн
- Гадаад валютын улсын нөөц 2025 оны 2 дугаар сарын эцэст 4,763 сая ам.доллар болж, өмнөх сараас 121 сая ам.доллоороор, өмнөх оны мөн үеэс 208 сая ам.доллоороор тус тус буурлаа.
 - Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 2 дугаар сард өдөрт дунджаар 0.9 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,467 төгрөгт хүрлээ.
 - Төв банк 2025 оны 2 дугаар сард нийт 683 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
 - Улмаар 2025 оны эхний 2 сарын нийт дуудлага худалдаа 1.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 68.8 хувиар буюу 595 сая ам.доллоороор өслөө.




Инфляц 2025 оны 2 дугаар сард 9.6 хувьд хүрч, өмнөх сараас 0.9 нэгж хувиар* эрчимжлээ. Инфляц өмнөх сараас эрчимжихэд хүнс, орон сууцны түрээс болон тээврийн бүлгийн үнийн өсөлт голлон нөлөөлжээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 1.4 хувиар өссөн байна.

*2023 оны суурьтай хэрэглээний үнийн улсын индекс

ЖИЛИЙН ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

САРЫН ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

СУУРЬ ИНФЛЯЦ


(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Инфляц 2025 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 9.6 хувьд гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.6 нэгж хувь (27.4 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 7.0 нэгж хувь буюу 72.6 хувийг эзэлж байна.

- 2025 оны 2 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.4 хувиар өсөв.
- Үүнд хүнсний бараа 2.1 хувиар, тээврийн үнэ 3.5 хувиар, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 1.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2025 оны 2 дугаар сард суурь инфляц 8.6 хувь гарч, нийт инфляцын 5.7 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 8 сар өссөн үзүүлэлттэй байна.

- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2025 оны 2 дугаар сард жилийн инфляцын 19 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар буурлаа.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 22.4 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ өмнөх оны мөн үеэс 25 хувиар буурчээ. Хүнсний үнийн индекс 2025 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ (хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

- Хүнсний инфляц 2025 оны 2 дугаар сард 9.3 хувь болж, нийт инфляцын 2.6 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хүнсний бус инфляц 9.7 хувь болж, нийт инфляцын 7.0 нэгж хувийг бүрдүүллээ. Хүнсний бус инфляц өмнөх сараас эрчимжихэд орон сууц, ус, цахилгаан, түлш болон тээврийн бүлгийн үнийн өсөлт голлох нөлөө үзүүллээ.


ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ (хувь)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, Монголбанк

- Төгрөгийн амдоллартой харьцах ханш 2025 оны 2 дугаар сард дунджаар 3,459 төгрөг болж, өмнөх сараас 0.8 хувиар сулрав.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2024 оны 1 дүгээр сарын байдлаар өмнөх сараас 0.5 хувиар өссөн байна.


ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ (1000\$/40 фут контейнер)



Эх сурвалж: Drewry World Container Index

- Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис/Суэцийн сувагт үүсээд буй халдлагаас үүдэлтэйгээр өсөөд байсан бол 2024 оны 2 дугаар хагасаас буурч эхэлсэн.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 2,368 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 25 хувиар буурсан байна.
- Чингэлэг тээврийн үнэ буурч байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг бууруулж байна.

ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС (хувь)



Эх сурвалж: FAO

- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2025 оны 2 дугаар сард 127.2 болж, өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар, өмнөх сараас 1.6 хувиар өссөн байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр элсэн чихэр, ургамлын тос, сүүн бүтээгдэхүүн, үр тарианы үнэ өссөн бол махны үнэ тогтвортой хадгалагдсан байна.




Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны 2 дугаар сард 4.0 их наяд төгрөг, нийт зарлага 4.6 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 566 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Нүүрсний үнийн бууралттай холбоотой төсөвт төвлөрөх орлого буурсан нь төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдалд голлон нөлөөлсөн байна.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ (их наяд төгрөг)




Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ОРЛОГО (орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)




Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ЗАРЛАГА (зарлагын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ) (Зүүн тэнхлэг: их наяд төгрөг, ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны 2 дугаар сард 566 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төсвийн тэнцэл өмнөх оноос 1.9 их наяд төгрөгөөр буурлаа.
- Нүүрсний үнийн бууралттай холбоотойгоор төсвийн орлого төвлөрүүлэлт саарсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл алдагдалтай гарахад голлон нөлөөлсөн байна.

- Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 4.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөг буюу 22.9 хувиар буурсан байна.
- Бууралтад орлогын албан татвар 592 тэрбум төгрөг буюу 30.3 хувиар, НӨАТ 120 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар, ААНОАТ 643 тэрбум төгрөг буюу 41.0 хувиар, нийт АМНАТ-ийн орлого 394 тэрбум төгрөг болж өмнөх оноос 63.6 хувиар буурсан нь голлон нөлөөлөд байна.

- Төсвийн зарлага 2025 оны 2 дугаар сард 4.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 830.4 тэрбум төгрөг буюу 22.1 хувиар нэмэгдсэн байна.
- Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2025.01.01-ны өдрөөс инфляцын түвшинд уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлсэн.
- Цалингийн хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 991 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 40.1 хувиар, тэтгэвэр тэтгэмж 1.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар тус тус өссөн байна.


- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны эцэст 33.4 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д эзлэх хувь 42.2 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 2 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өсөж, 41.8 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 2 дугаар сард 38.4 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 38.0 хувьд хүрлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ


(жилийн өсөлт, хувь)



Эх сурвалж: Монголбанк

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ


(жилийн өсөлт, хувь)



Эх сурвалж: Монголбанк

ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

(хувь)



Эх сурвалж: Монголбанк

ХҮҮГИЙН ТҮВШИН

(жигнэсэн дундаж хувь)



Эх сурвалж: Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 2 дугаар сарын эцэст 41.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 11.2 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 12.1 нэгж хувь, төгрөгийн харилцах 1.8 нэгж хувь, гадаад валютын харилцах -3.3 нэгж хувь, гадаад валютын хадгаламж -0.3 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.


- Нийт хадгаламж 26.9 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 19.8 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 22.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.0 хувиар, өмнөх сараас 2.4 хувиар өслөө.
- Гадаад валютын хадгаламж 4.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар, өмнөх сараас 1.6 хувиар буурлаа.

- Банкнүүдэн зээлийн үлдэгдэл 2025 оны 2 дугаар сарын эцэст 38.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 38.0 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар буурсан байна.

- Банкнүүдэн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 2 дугаар сард 17.1 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар өслөө.
- Банкнүүдэн шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 2 дугаар сард 11.3 хувь болж, өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурлаа.



Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээл идэвхжиж 2024 оны 4 дүгээр улиралд ажилчдын тоо 1 сая 353 мянга, ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувьд хүрлээ.



- Ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 31 мянга буюу 2 хувиар нэмэгдэж 1 сая 353 мянгад хүрсэн нь цар тахлын өмнөх үеэс 165 мянгаар өндөр үзүүлэлт юм.
- 2024 оны 4 дүгээр улиралд эрэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 21.8 мянгаар, эмэгтэй ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 9.4 мянгаар тус тус өссөн байна.

- Ажилчдын тооны өсөлтөд үйлчилгээ ба бусад, худалдаа, барилгын салбарын ажилчид нэмэгдсэн нь эергээр нөлөөлсөн байна.
- Харин хөдөө аж ахуйн салбарын ажилчид, мөн боловсруулах, уул уурхайн салбарын ажилчдын тоо буурсан нь сөргөөр нөлөөллөө.

- Ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар, цар тахлын өмнөх үеэс 1.5 нэгж хувиар өслөө.
- Харин ажилгүй иргэдийн тоо 2024 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 22 мянган хүнээр өсөж 75.4 мянгад хүрсэн байна. Ингэснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 1.4 нэгж хувиар өсөж 5.3 хувьд хүрчээ.

- Дундаж цалингийн хэмжээ 2024 оны 4 дүгээр улиралд байдлаар өмнөх оны мөн үеэс 19.5 хувиар өсөж, 2 сая 672 мянган төгрөгт хүрлээ.
- Улсын голч цалин 2024 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 25 хувиар өсөж, 2 сая 229 мянган төгрөг (дундаж цалингаас 442 мянган төгрөгөөр бага) болов. Энэ нь ажилчдын талаас илүү нь дундаж цалингаас бага цалин авч байгааг илэрхийлж байна.
- Салбараар авч үзвэл уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараа тэргүүлж улсын дунджаас 2 дахин өндөр байна.



Өрхийн бодит орлого сүүлийн 7 улирал дараалан өссөн ч өсөлтийн хурд саарлаа.

ӨРХИЙН БОДИТ ОРЛОГЫН ӨСӨЛТ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн бодит орлогын өсөлт 5.9 хувь болж, өсөлтийн хурд суурийн нөлөөгөөр саарлаа.
- Бодит орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого өмнөх оны мөн үеэс 233 мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 76 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

БОДИТ ОРЛОГЫН БҮТЭЦ

(хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн дундаж бодит орлогод эзлэх цалингийн орлогын хэмжээ 57.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.3 нэгж хувиар нэмэгдсэн байна.
- Үүнд дундаж цалингийн өсөлтөөс гадна хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн нь нөлөөлж байна.

ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО

(сая төгрөг)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бага орлоготой өрхийн орлого төдийлөн өсөхгүй байна.
- Нийт өрхийн 43.7 хувийг бүрдүүлж буй 1.6 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого оны үнээр 981 мянган төгрөг байна.
- Харин 1.6 сая төгрөгөөс дээш орлоготой өрхүүдийн сарын дундаж орлого 3,207 мянган төгрөг байна.

ӨРХИЙН ДУНДАЖ НЭРЛЭСЭН ОРЛОГО

(сая ₮)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Нийслэлийн өрхийн дундаж орлого 3.1 сая төгрөгт хүрсэн бол хөдөө орон нутгийн өрхийн орлого бага байна.
- Нийслэлийн өрхийн орлогын 65.4 хувийг цалингийн орлого бүрдүүлж байхад хөдөөгийн өрхийн орлогын 15.2 хувийг цалингийн орлого, 37 хувийг хөдөө аж ахуйн орлого бүрдүүлж байна.



Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2024 оны эцэст 261.2 мянгад хүрч өмнөх оны эцсээс 24.7 мянгаар буюу 10.4 хувиар нэмэгдлээ.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО

(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)



- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2024 оны эцэст 261.2 мянгад хүрч өмнөх оны эцсээс 24.7 мянгаар буюу 10.4 хувиар нэмэгдлээ.
- Уг өсөлтийн 19.2 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 6.8 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүллээ.
- Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдэж байгаа нь бизнесийн үйл ажиллагаа идэвхижиж байгааг илтгэж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ


(ААН-ийн тоо, салбараар)



- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН 3.8 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 43 хувиар өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО


(мянга, ажиллагчдын тоогоор)



- Үйл ажиллагаа явуулж буй 108.4 мянган ААН-ийн 93.5 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 91 хувийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС

(улирлаар, 2018=100)




- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2024 оны 4 дүгээр улиралд 104.7-д хүрч өмнөх оны мөн үеэс 16.7 нэгжээр сайжирлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 32.9 нэгж, эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтэйг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 11.5 нэгжээр тус тус нэмэгдсэн байна.
- Үүнд, хэрэглэгчид ажлын олдоц болон бизнесийн нөхцөлийг одоо болон ирээдүйд сайнаар үнэлсэн нь голчлон нөлөөлжээ.



ОХУ-ын эдийн засаг 2024 онд 4.1 хувиар өслөө. Төв банкнаас бодлогын хүүг 2024 оны 10 дугаар сард 2 нэгж хувиар өсгөж, 21 хувьд хүргээд байна. Харин инфляцын түвшин 2025 оны 2 дугаар сард 10.1 хувьд хүрч, өмнөх сараас 0.2 нэгж хувиар өслөө.

БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- ОХУ-ын эдийн засаг 2024 онд өмнөх оноос 4.1 хувиар өслөө.
- Улмаар эдийн засгийн өсөлт өмнөх онтой ижил түвшинд хадгалагдлаа.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(хувь, тухайн сар)




Эх сурвалж: Блүүмберг

- 2025 оны 1 дүгээр сарын байдлаар экспорт 29.2 тэрбум ам.доллар, импорт 22.1 тэрбум ам.долларт тус тус хүрч, худалдааны тэнцэл 7.2 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2025 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өслөө.
- Импорт 2025 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өслөө.

ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Блүүмберг

- Инфляцын түвшин 2025 оны 2 дугаар сард 10.1 хувь болж, өмнөх сараас 0.2 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 2.4 нэг хувиар тус тус өссөн байна.
- ОХУ-ын инфляц зорилтот түвшин 4 хувиас өндөр хэвээр байна.
- ОХУ-ын Төв банкнаас 10 дугаар сарын 25-ны өдөр бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 21 хувьд хүргэх шийдвэр гаргасан.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)

(нэгж, хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2025 оны 2 дугаар сард 50.2 болж, өмнөх сараас 2.9 нэгжээр буурлаа.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2025 оны 1 дүгээр сарын байдлаар 2.2 хувь болж, өмнөх сараас 6 нэгж буурлаа.



БНХАУ 2025 оны эдийн засгийн зорилтот өсөлтийг 5.0 орчим хувь байхаар зарлалаа. 2025 оны эхний 2 сарын байдлаар экспортын өсөлт хүлээлтээс бага, импортын агшилт өндөр байв. Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 2 дугаар сард сөрөг утгатай гарлаа.




- Экспорт 2025 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өссөн нь 2024 оны 4 дүгээр сараас хойших хамгийн бага өсөлт боллоо.
- Импорт 2025 оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар буюу 2023 оны 7 дугаар сараас хойших хамгийн их хувиар агшлаа.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик 3 дугаар сард нэгтгэгдэн зарлагддаг.




- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2025 оны эхний 2 сард 5.9 хувьд хүрч саарлаа.
- Жижиглэн худалдааны өсөлт 2025 оны эхний 2 сард 4.0 хувьд хүрч эрчимжлээ.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик 3 дугаар сард нэгтгэгдэн зарлагддаг.



- Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт 2025 оны 2 дугаар сард -0.7 хувьд хүрч, 2024 оны 1 дүгээр сараас хойш анх удаа сөрөг утгатай гарлаа.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 2 дугаар сард -2.2 хувь гарч, үнийн уналт үргэлжилж байна.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 2 дугаар сард 50.2 болж, тэлэлтийг илтгэх босго утга 50-аас их түвшинд эргэн очлоо.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд өмнөх сараас буурсан ч босго утга 50-аас өндөр хэвээр хадгалалдаг.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжиллийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажиг эрхлэлт, түүний эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ